

Сургалтын дасгал ажлууд

Өдөр 1	Дасгал ажил №1: Гурван дэд хөтөлбөр эсвэл багц арга хэмжээг тодорхойлох
Оролцогч бүр дараах зүйлсийг бие даан гүйцэтгэнэ. Үүнд:	
1) Таны буюу танай байгууллагын эрхлэх асуудал, чиг үүрэгт хамаарах, та өөрчлөлт хийж нөлөөлөх эрх мэдэлтэй буюу боломжтой 3 хөтөлбөр, дэд хөтөлбөр эсвэл арга хэмжээг тодорхойлно.	
2) Танай байгууллагад санхүүгийн хувьд ихээхэн нөлөө үзүүлдэг, их хэмжээний төсөв зарцуулдаг нэг хөтөлбөр (дэд хөтөлбөр эсвэл багц арга хэмжээ)-ийг тодорхойлно.	
3) Орон нутгийн ард иргэдэд чухал нөлөөтэй (өөрөөр хэлбэл, төсвийн үр нөлөөнөөс илүү нийгмийн ба улс төрийн ач холбогдол бүхий) нэг хөтөлбөрийг тодорхойлно.	
4) Эмэгтэйчүүд үр шимийг нь бага хүртдэг хэмээн бодож буй нэг хөтөлбөр (дэд хөтөлбөр эсвэл багц арга хэмжээ)-ийг тодорхойлно.	
5) Гурван хөтөлбөрөө 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичнэ.	
6) Бүх оролцогч харж танилцах боломжтой байлгах үүднээс дээрх №2, №3-т бичсэн хоёр хөтөлбөрийн нэрийг цаасан дээр бичиж урдаа наана.	
7) Оролцогчдод хоёр хөтөлбөрөө (дэд хөтөлбөр эсвэл багц арга хэмжээ) товч танилцуулж, тэдгээр хөтөлбөр яагаад чухал болохыг тайлбарлана.	
Өдөр 2	Дасгал ажил №2: Сонгосон нэг хөтөлбөрийнхөө цар хүрээг тодорхойлох
Оролцогчид 2-3 хүнтэй багт хуваагдан, дараах зүйлсийг гүйцэтгэнэ. Үүнд:	
1) Кейс ажиллах үүднээс гурван хөтөлбөрөөсөө (дэд хөтөлбөр эсвэл багц арга хэмжээ) нэгийг нь сонгон авна.	
2) Хавсралт 6 (111-р нүүр)-гийн Хүснэгт 1 -ийг ашиглан хөтөлбөр (дэд хөтөлбөр, багц арга хэмжээний) цар хүрээг тодорхойлно.	
3) Хүснэгт 1-ийг бөглөх замаар өөрийн сонгосон хөтөлбөр, дэд хөтөлбөр, багц арга хэмжээг сургагч багш, анги нийтэд танилцуулахад бэлтгэнэ.	
4) Багийн ажлаа танилцуулна.	
Өдөр 2	Дасгал ажил №3: Перу Улсын кейсийн шинжилгээ
Кейсийн шинжилгээ: Ла Либертадын Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах хөтөлбөр (Перу Улс) тараах материалыг үзнэ үү.	
Өдөр 2	Дасгал ажил №4: Сонгосон хөтөлбөрийн төлөв байдлыг (эрх тэгш байдлыг хангаж, тэгш хүртээмжтэй байж чадаж байгаа эсэхийг) тодорхойлох
Багаараа дараах зүйлсийг гүйцэтгэнэ. Үүнд:	
1) Дасгал ажил №2-оос гарсан үр дүн, сонгосон хөтөлбөр (дэд хөтөлбөр, багц арга хэмжээ)-ийн талаарх өөрийн мэдлэг мэдээлэлд тулгуурлан Хавсралт 6 (111-112-р нүүр)-гийн Хүснэгт №2, Хүснэгт №3 -ыг тус тус бөглөнө.	
2) Үр шим хүртэгчдийн тоо байхгүй тохиолдолд тоог нь аль болох үндэслэлтэй таамаглана. Ажилдаа эргэн очоод тэр тоог шалгаж, баталгаажуулна.	
3) Хүснэгт №2, №3-ыг бөглөх замаар өөрийн хөтөлбөр, дэд хөтөлбөр, багц арга хэмжээг сургагч багш, бүлэгт танилцуулахад бэлтгэнэ.	

4) Багийн ажлаа танилцуулж, танай хөтөлбөр жөндөрийн эрх тэгш байдлыг хангаж чадаж байгаа эсэх талаар тодорхой дүгнэлт хэлнэ.	
Өдөр 3	Дасгал ажил №5: Монголын кейс ажиллах: Шалтгааныг шинжлэх
Оролцогч бүр:	
1) 112-р нүүрний диаграмыг үзэж, та эдгээрийн алийг нь өөрчлөх байсныг тодорхойлно.	
2) Санал зөвлөмжөө нийтэд танилцуулах бэлтгэлтэй байгаарай.	
Өдөр 3	Дасгал ажил №6: Багийн гишүүд анги нийтэд танилцуулах илтгэл бэлтгэхийн тулд ажил үүргээ хуваарилан авах
1) Өөрийн хөтөлбөрт харгалзах “Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ /шийдэл” -г танилцуулах илтгэл /Баасан гарагийн бага, их үдэд танилцуулах/ бэлтгэнэ.	
2) Хариуцах ажлаа хуваан авч, багийн аль нэг гишүүнд Хүснэгт 1-3 болон зохих мэдээллийг нэгтгэн, илтгэл танилцуулга бэлтгэх ажлыг даалгана.	
3) Багийн өөр нэг гишүүнд мэдээллийг нэгтгэн, 113-р нүүрний маягтыг бөглөх ажлыг даалгана.	
4) Ажил үүргээ аль болох тэнцүү хувааж гүйцэтгэнэ.	
Өдөр 3	Дасгал ажил №7: Сонгосон хөтөлбөрийнхөө зөрүүтэй байдлын шалтгаанд дүн шинжилгээ хийх
Багаараа дараах зүйлсийг гүйцэтгэнэ. Үүнд:	
1) Дасгал ажил №4-ийн үр дүнд үндэслэн зөрүүтэй байдал байгаа эсэхийг тогтоож, хэрэв байвал “Загасны ясан диаграм” -ыг ашиглан зөрүүтэй байдал үүсгэсэн байж болзошгүй шалтгааных нь талаар таамаглана.	
2) Өөрийн хөтөлбөрт шинжилгээ хийсэн диаграмаа нийтэд танилцуулахад бэлтгэнэ.	
Өдөр 3	Дасгал ажил №8: Шалтгаанаас зорилт руу шилжих
Багаараа дараах зүйлсийг гүйцэтгэнэ. Үүнд:	
1) 112-р нүүрний диаграм, хөтөлбөрт тодорхойлсон ерөнхий шалтгаанд тулгуурлан нөхцөл байдлыг бодитойгоор сайжруулахын тулд байгууллага ямар зорилго тавьж, ажиллаж болно гэж бодож байгаагаа багаараа хэлэлцэнэ.	
2) Нэг жилийн хугацаанд тухайн зорилтот түвшинд хүрэхийн тулд ямар арга хэмжээ авах, үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатайг багаараа хэлэлцэнэ.	
3) Үүнийгээ нийтэд танилцуулахад бэлтгэнэ.	
Өдөр 4	Дасгал ажил №9: Зөрүүтэй байдлын шалтгааныг шийдвэрлэхийн тулд Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ /шийдэл/ боловсруулах
Багаараа дараах зүйлсийг гүйцэтгэнэ. Үүнд:	
1) Дасгал ажил №7-гийн үр дүнд тулгуурлан 104-106-р нүүрэн дэх бичил төслийг жишээ болгон өөрийн хөтөлбөрт тохирох бичил төсөл боловруулна.	
2) Нийт оролцогчдод танилцуулахад зориулан илтгэл /20 минутын/ бэлтгэнэ. Тухайн илтгэлдээ өмнөх дасгал ажлын хүрээнд гүйцэтгэсэн Хүснэгт №1-3, Ишикава диаграм болон бичил төслийн гол агуулгыг заавал оруулна.	